



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2025 ОНЫ
НӨХӨН СОНГУУЛЬ”-Д ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР
ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, ОЛОН
НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

АУДИТЫН КОД: ХОА-2025/124-ШТА-НА

Ховд хот
2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn
Аудитор: Ц.Аззаяа
Утас: 7043-2545 Цахим хаяг: Azzayats@audit.gov.mn



ХҮСНЭГТ ГРАФИКИЙН ТОВЬЁГ	1
ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ	1
НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
ХОЁР. ЯВЦЫН ТАЙЛАН, МЭДЭЭ	5
ГУРАВ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН	5
3.1 Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан	6
3.2 Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл, үлдэгдэл	7
3.4 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал	7
ДӨРӨВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	7
4.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар	83
ТАВ. ДҮГНЭЛТ	84

ХҮСНЭГТ ГРАФИКИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт, эх үүсвэр	5
Хүснэгт 2	Сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлын гүйцэтгэл	6

ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилтийн дүн	9
Хавсралт 2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дүн	9
Хавсралт 3	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт	10



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНСДИТХСТ	Аймаг нийслэл сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НА	Нотлох ажил
ХАК	Хувийн аудитын компани
ХОА	Ховд аймаг дахь Төрийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах ажил



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 4/30

Ховд

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсэг, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулж олон нийтэд мэдээлсүгэй.

2. Ажлын болон нотлох баримтын иж бүрдлийг ханган архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Ц.Аззаяа)-д, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг нийцлийн аудитын багт хариуцуулсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг аудитын менежер (А.Цэцэгсүрэн)-д даалгасугай.



Х.БОЛДБААТАР

Тушаал-2025

8425010090



НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд АНСДИТХСТ хуулийн 57 дугаар зүйлийг үндэслэн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалт, гүйцэтгэл”-д аудит хийлээ.

Аудитын зорилт:

Сумдын ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний зарцуулалтын тайланг хянаж, дүгнэлт гаргах, хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийг нийтэд мэдээлэхэд оршино. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Нам эвсэл, нэр дэвшигч нь сонгуульд зарцуулах хөрөнгийн санхүүжилтийг хуулийн дагуу бүрдүүлсэн эсэх
- Хөрөнгийг хууль, журамд заасны дагуу зарцуулсан эсэх

Аудитын хамрах хүрээ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлт, харилцагч банкны дансны хуулга, бусад шаардлагатай баримт, материалуудыг хамруулсан.

Тус сонгуульд 3 сумын 6 намаас 6 иргэн нэр дэвшсэн бөгөөд төрийн аудитын байгууллагад 6 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн байна.

Аймаг Нийслэл Сум Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5¹-д заасны дагуу арилжааны 2 банкнаас сонгуулийн зардлын данс нээлгэсэн нэр дэвшигчдийн дансны хуулгыг ирүүлсэн байна.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4000 дугаар стандартууд, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817-6:2020, МУЕА-ын тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”, “Нийцлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан сонгуулийн зардлын тайлангийн талаар нам эвсэл, нэр дэвшигч, ХАК-ний холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, гаргасан дүгнэлтийн мэдээллийг нэгтгэх, хандив өгсөн иргэн, аж ахуйн нэгжийн талаарх тодруулгыг УБХ-ээс авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулах дүгнэлт боловсруулж нийтэд мэдээлнэ.

Дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар “Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг мөрдлөг болгосон.

¹Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ



ХОЁР. ЯВЦЫН ТАЙЛАН, МЭДЭЭ

2.1. АНСДИТХС-ийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2² заасны дагуу сумдын 4 нам, 3 нэр дэвшигч зардлын данс нээлгэсэн боловч хуулийн 50 дугаар зүйлийн 50.2³-д зааснаар Төрийн аудитын байгууллагад сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг ирүүлж бүртгүүлээгүй байна.



2.2 Сонгуулийн зардлын дансны мэдээллийг бүртгүүлээгүй нам, нэр дэвшигчийн жагсаалтыг хуулийн дагуу шалган шийдвэрлүүлэхээр АНСДИТХС-ийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3⁴, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12⁵-т заасны дагуу аймгийн Татварын хэлтэст хүргүүлээ.



Аудитын илрүүлэлт

Сумдын ИТХ-ын нөхөн сонгуульд оролцсон 3 сумын 6 нам, 6 нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэх, бүртгүүлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

ГУРАВ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

3.1 Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан

3.1.1 АНСДИТХС-ийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад 3 сумын 3 нам, 6 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлжээ.

3.1.2 АНСДИТХС-ийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5⁶-д заасны дагуу Ховд аймаг дахь Төрийн банкны салбар зардлын данс нээлгээгүй тухай албан бичиг ирүүлж, Хаан банкны салбар 3 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансны гүйлгээний хуулга ирүүлсэн байна

3.2 Сонгуулийн зардлын санхүүжилт, гүйцэтгэл, үлдэгдэл

3.2.1 Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн 6 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг нэгтгэхэд 5 нэр дэвшигч нийт 5,078.4 мянган төгрөгийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлэн, 2,578.4 мянган

²50.2 Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ.

³50.2 Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

⁴ 57.2.3 Сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх.

⁵ 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил.

⁶ Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.



төгрөгийн зардал гарган, 2,500.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн, үлдэгдэлтэй тайлагнасан байна.

3.2.2 Сонгуульд оролцсон намууд орлого бүрдүүлж, зарцуулаагүй гэж тайлагнасан байна.

3.2.3 Дарга тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/13 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг Дарви сумын Дэлгэр багт 9.2, Манхан сумын Төгрөг гол багт 10.5, Мянгад сумын Баянбулаг багт 9.2 сая төгрөгөөр тогтоосон ба сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид тогтоосон хэмжээнд зардал гаргасан байна.

3.2.4 Нийт 5 нэр дэвшигч сонгуулийн зардлын эх үүсвэрт нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөөс 878.4 мян төгрөг, мөнгөн хандиваар 4,200.0 мян төгрөгийн, нийт 5,078.4 мян төгрөг бүрдүүлсэн гэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Сонгуулийн зардлын санхүүжилт, эх үүсвэр /Нэр дэвшигч/ /мян төгрөг/

д/д	Санхүүжилт, эх үүсвэр	Нэр дэвшигчийн тоо	Дүн /мян төгрөг/	Иргэн, Хуулийн этгээдийн тоо
1	Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	0	0	-
2	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	3	878.4	3
	Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив	0	0	0
3	Үүнээс: Мөнгөн хандив	0	0	0
	Мөнгөн бус хандив	0	0.0	0
	Иргэний өгсөн нийт хандив	3	4,200.0	4
4	Үүнээс: Мөнгөн хандив	3	4,200.0	4
	Мөнгөн бус хандив	0	0.0	0
	Нийт дүн	6	5,078.4	7

Эх сурвалж: Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

3.2.5 Сонгуулийн үйл ажиллагаанд нийт 4 нэр дэвшигч 2,578.4 мянган төгрөгийг зарцуулснаас тээврийн хэрэгслийн зардалд 1,778.0 мянган төгрөг, цахим орчин ашиглах зардалд 338.2 мянган төгрөг, бусад зардалд 462.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 2. Сонгуулийн зардлын гүйцэтгэл(мян.төг)

д/д	Зардлын ангилал	Нэр дэвшигчийн тоо	Дүн /мян төгрөг/	Эзлэх хувь
1	Сонгуулийн зардал	4	2,578.4	100%
1.1	Үүнээс: сонгуулийн сурталчилгааны материал	0	0	0%
1.2	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд	0	0	0%
1.3	Нам эвсэл нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	4	1,778.0	68.9%
1.4	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх	0	0	0%




1.5	Сонин сэтгүүлд материал хэвлүүлэх	0	0	0%
1.6	Ухуулагч /Менежерийн урамшуулал/	0	0	0%
1.7	Цахим орчин ашиглах зардал	1	338.2	13.1%
1.8	Бусад зардлын дүн	1	461.8	17.9%
Нийт дүн		6	2,578.4	100

Эх сурвалж: Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан

3.4 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал

3.4.1 Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд нийт 2 аудитын хуулийн этгээд аудит хийж Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар “Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу баталгаажуулан ирүүлсэн байна.



3.4.2 Аудитын хуулийн этгээдүүдийн баталгаажуулан ирүүлсэн тайланг хянаж, нэгтгэх явцад 1 нэр дэвшигчийг орлого, зарлага гаргаагүй тухай дүгнэлт гаргасан байхад банкнаас ирүүлсэн хуулгаар орлого орсон нь тогтоогдсон тул аудитын явцад залруулсан болно.

ДӨРӨВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

4.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар

4.1.1-ийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1⁷ д заасны дагуу төрийн аудитын байгууллагаас нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээллийг Хавсралт 3-д нэгтгэв.

4.1.2 Хавсралт 3-д дурдсан 2 иргэн 3,500.0 мянган төгрөгийн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандивыг 2 нэр дэвшигчид өгсөн байна..

4.1.3 Намд иргэн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандив, хуулийн этгээд хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн мөнгөн хандивыг тус тус өгөөгүй байна. *Хавсралт 3.*

4.1.4 Төрийн аудитын дээд байгууллагаас иргэн, хуулийн этгээдээс өгсөн дээрх

⁷ 57.1. Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.



хандивын мэдээллийг open.audit.mn сайтад байршуулж, нийтэд ил тод мэдээлэв.

ТАВ. ДҮГНЭЛТ

“Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль”-д нам, нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нэгтгэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Нөхөн сонгуулийн 3 тойрогт нийт 6 нам, 6 иргэн нэр дэвшсэнээс 6 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан хуулийн хугацаанд ирүүлсэн байна.
2. Сонгуулийн зардалд нийт 5 нэр дэвшигч 5,078.4 мянган төгрөгийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлж, 2,578.4 мянган төгрөгийн зардал гаргаж, 2,500.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.
3. Нэр дэвшигчдийн сонгуулийн үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн санхүүжилтээс 2,500.0 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг зохицуулах хууль, эрх зүйн орчин тодорхой бус байна.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Хавсралт 1

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт

/мянган төгрөг/

№	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог нэр	Нийт орлогын дүн	Үүнээс					
					Нам эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Хуулийн этгээдийн		Иргэний	
							Тоо	Өгсөн хандив	Тоо	Өгсөн хандив
1	Мянгад сум 2-р баг Буянбулаг	Монгол Ардын Нам	Нямгэрэл Батболд	-						
2	Дарви сум 2-р баг Дэлгэр	Монгол Ардын Нам	Батчулуун Ганзориг	2,500.0					1	2,500.0
3	Дарви сум 2-р баг Дэлгэр	Ардчилсан Нам	Ганболд Тарваа	278.4		278.4				
4	Манхан сум 6-р баг Төгрөг гол	Монгол Ардын Нам	Доноров Наранхүү	300.0		300.0				
5	Манхан сум 6-р баг Төгрөг гол	Ардчилсан Нам	Батхүү Жаргалмаа	1,800.0		300.0			2.0	1,500.0
6	Мянгад сум 2-р баг Буянбулаг	Ардчилсан Нам	Жамсранжав Төрмөнх	200.0					1	200.0
НИЙТ				5,078.4	-	878.4	-	-	4.0	4,200.0

Хавсралт 2

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалт

/мянган төгрөг/

№	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог нэр	Нийт зардлын дүн	Зардлын ангилал								
					Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг уриа	Сонгогчидтой уулзалт хурал, цуглаан хийх	Сонгуулийн үйл ажиллагаа/гүрээс, урамшуулал, тээвэр, томилолт, сурталчилгаа/	Сонгуулийн сурталчилгаанд радио телевиз ашиглах	Цахим орчин ашиглах зардал	Сонин сэтгүүлд материал хэвлүүлэх	Бусад зардал
1	Мянгад сум 2-р баг Буянбулаг	Монгол Ардын Нам	Нямгэрэл Батболд	0									
2	Дарви сум 2-р баг Дэлгэр	Монгол Ардын Нам	Батчулуун Ганзориг	0									
3	Дарви сум 2-р баг Дэлгэр	Ардчилсан Нам	Ганболд Тарваа	278.4					278.0				0.4
4	Манхан сум 6-р баг Төгрөг гол	Монгол Ардын Нам	Доноров Наранхүү	300.0					300.0				
5	Манхан сум 6-р баг Төгрөг гол	Ардчилсан Нам	Батхүү Жаргалмаа	1,800.0					1,000.0		338.2		461.8
6	Мянгад сум 2-р баг Буянбулаг	Ардчилсан Нам	Жамсранжав Төрмөнх	200.0					200.0				
НИЙТ				2,578.4	0	0	0	0	1,778.0	0	338.2	0	462.2



Хавсралт 3

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон иргэнд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт

Д/ Д	Нам, Эвслийн нэр	Овог	Нэр	Хандив өгсөн иргэн болон хуулийн этгээдийн нэр	/мянган төгрөг/ Мөнгөн хандивын дүн	
					Иргэн /Нэг сая төгрөгөөс дээш/	Хуулийн этгээд /Хоёр сая төгрөгөөс дээш/
1	Ардчилсан Нам	Батхүү	Жаргалмаа	З.Эрхбаяр	1,000.0	
2	Монгол Ардын нам	Батчулуун	Ганзориг	О.Ганцоож	2,500.0	
Нийт дүн					3,500.0	